

ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛЫН ТӨСЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна. гэж, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, түүний байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасан.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтад 1.1.Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална: 1.1.1.байгалийн баялаг ард түмний мэдэлд, төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны үр өгөөж /татвар, ашиг гэх мэт/-ийн дийлэнх нь буюу тавиас дээш хувь нь монголын ард түмэнд ногдох, шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах; гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2-т “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно” гэж заасан бөгөөд энэ зорилгын хүрээнд нийцүүлэн тодорхойлсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг төрийн бодлогоор онцгойлон дэмжихээр тусгасан.

Уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох болон экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх ба үүнээс “Нэмүү өртөг шингээсэн уул уурхай, стратегийн мега төслүүд, боловсруулах аж үйлдвэр түүнийг дагасан үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдлэгжсэн бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ. Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. Уул уурхайн түүхий эдийг боловсруулан, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй, тогтвортой байх зарчмаар хөгжүүлж, хөрөнгө оруулалтын дэвшилтэт хэлбэрүүдийг дэмжинэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогод “эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд “Байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглаж, хамгаалж, нөхөн сэргээнэ, үйлдвэр, үйлчилгээг хоршилт, төрөлжилт, дагналт, кластерын бодлогоор дэмжинэ, бүс, орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд “хариуцлагатай уул уурхайг дэмжинэ, геологи, хайгуулын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр стратеги, бодлого боловсруулна, стратегийн ордуудаас Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна, ашигт малтмалын нөөцийг өсгөнө. гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг өнөө болон ирээдүй цагийн иргэдэд ижил, тэгш хүртээх зорилгоор үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэн зарцуулахад чиглэсэн. Энэ ч агуулгаар тус сангийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор стратегийн ач холбогдолтой гэж тодорхойлох ордын дийлэнхийг төр үнэ төлбөргүйгээр эзэмших зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуульд оруулсан нь салбарын хувьд ихээхэн эрсдэл бүхий нөхцөл байдлыг бий болгоод байна.

Өөрөөр хэлбэл, ордын нөөц өндөр байх тохиолдолд төр уг ордыг үнэ төлбөргүйгээр өөртөө шилжүүлж авах эрх зүйн орчинг бүрдүүлсэн нь салбарт оруулах хөрөнгө оруулалтыг шууд царцаах, хязгаарлах шинжтэй зохицуулалт болсон ба уг зохицуулалт нь Үндсэн хуульд заасан өмчийн эрхийг шууд зөрчихөөр байна. Үүний улмаас ордын нөөцийг нэмэгдүүлэх төрийн бодлогод ч сөргөөр нөлөөлөх ба нэмж нөөц тогтоох хувийн хайгуулын ажлууд ч зогсохоор байна.

Үндсэн хуулийн зорилго нь газрын хэвлийг баялгийн үр өгөөжийг нэмэгдүүлэн, түүнийг үр дүнтэйгээр ашиглахад чиглэсэн. Иймээс ч газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх асуудлыг зөвхөн их хэмжээний нөөцтэй ордод хамаарах ашигт малтмалаас бус Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хөндөгдөж буй ашигт малтмал бүрээс үр өгөөжийг төвлөрүүлэх нь Үндсэн хуулийн зорилгод нийцэх юм.

Байгалийн баялгийн үр өгөөжийг төр хувь эзэмших замаар ногдол ашиг хүртэхээс гадна, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хэлбэрээр төвлөрүүлж болохыг Улсын Их Хурлаас тогтоосон. Иймээс ч уул уурхайн салбарын татварын ачаалалд үндэслэн, үр өгөөжийн хэлбэр, хэмжээг тодорхойлох нь зүйтэй байна.

Түүнчлэн, манай улс баялгийн сангаар дамжуулан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг хүртэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн ч сангийн орлогыг бүрдүүлэх салбарыг дэмжин, газрын хэвлийн баялгийг үр ашигтайгаар ашиглах замаар түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудалд бодлогын тодорхой дэмжлэг хараахан байхгүй байна. Монгол Улсын эдийн засаг нь бүхэлдээ уул уурхайгаас хамааралтай бөгөөд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ашиглах бодлого нь уул уурхайг дагасан эдийн засгийн бусад салбарыг дэмжих замаар улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой заасан. Иймээс ч хязгаарлагдмал нөөцийг хариуцлагатайгаар, үр дүнтэйгээр ашиглахад нь дэмжлэг үзүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд, дээрх үндэслэлээр Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн зорилго нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх, ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагааг дэмжин, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгоход чиглэнэ.

Хуулийн төсөл нь үндсэн 5 бүлгээс бүрдэх ба 1 дүгээр бүлэгт хуулийн зорилт, зарчим бүхий нийтлэг харилцааг тусгах бол, 2 дугаар бүлэгт чухал ашигт малтмалын төслийн төрөл, бүртгэлийн талаарх зохицуулалтыг, 3 дугаар бүлэгт чухал ашигт малтмалын үр өгөөж ба төсөлд үзүүлэх дэмжлэгийн харилцааг, 4 дүгээр бүлэгт чухал ашигт малтмалын төслийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, тайлагнал, 5 дугаар бүлэгт хууль зөрчихтэй холбоотой бусад харилцааг тус тус зохицуулна.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хувийн өмчийн эрхийг зөрчихгүйгээр, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Төрийн нийтийн өмчийн үр өгөөжийг хуульд тодорхойлсноор,

бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой болж, бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Түүнчлэн, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор хайгуулын ажил эрчимжин, Монгол Улсын газрын хэвлийн баялгийн нөөц нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээс гадна, уул уурхайн төслөөс хүртэх нийгмийн үр өгөөжийг тодорхойлж, нөлөөлөлд өртөх иргэдийн эрх, ашгийг хангах нөхцөл бүрдэнэ.

Энэхүү хуулийн төслийн үр дүнд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ордын том, жижгээс үл хамааран ижил, тэгш нөхцөлөөр хүртэх эрх зүйн орчин бүрдэх ба Үндэсний баялгийн сангийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. Ингэснээр өнөө болон ирээдүйн цагийн иргэдийн байгалийн баялгаас хүртэх өгөөжийг нэмэгдүүлж, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэх нөхцөл бүрдэх юм.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй хамт Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---